# Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: ГЛОБАЛ УДИРДАГЧ ИХ СУРГУУЛЬ
СУВИЛАХУЙН СУРГУУЛЬ

Хөтөлбөрийн нэр: СУВИЛАХУЙ

Индекс: D091301

Шинжээчийн баг:
Ахлагч: Г. Хулан

Гишүүд: С. Гантуяа
Б. Булганцэцэг

Улаанбаатар хот, 2022.02.23

# Агуулга


**I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**
**II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**
**III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт
**IV. Уулзалтад оролцогчдын нэрс**
I. Багш нарын нэрс
II. Оюутнуудын нэрс
III. Ажил олгогчдын нэрс
IV. Төгсөгчдийн нэрс
**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

# I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<table>
<tr><td>Сургуулийн нэр /Монгол, Англи/</td><td colspan="2">Глобал Удирдагч их сургууль, Сувилахуйн сургууль</td></tr>
<tr><td>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</td><td colspan="2">Сувилахуй</td></tr>
<tr><td>Индекс</td><td colspan="2">D091301</td></tr>
<tr><td>Шинжээчид</td><td colspan="2">Ахлагч:<br>1. Г. Хулан, АШУҮИС-ийн Эрдмийн сургуулийн ахлах багш, сувилахуйн ухааны доктор<br>Гишүүд:<br>2. С. Гантуяа, ЭМЯ-ны дэргэпэх Азийн хөгжлийн банкны төслийн зөвлөх<br>3. Б. Булганцэцэг, Ач анагаах ухааны их сургуулийн Сувилахуйн тэнхимийн эрхлэгч</td></tr>
<tr><td>Зохицуулагч</td><td colspan="2">Б.Оюунчимэг - Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч</td></tr>
<tr><td rowspan="8">Төлөвлөгөө</td><td>Он сар өдөр</td><td>Хийгдсэн байх ажлууд<br>/Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу</td></tr>
<tr><td>1 сарын 14</td><td>Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон.</td></tr>
<tr><td>1 сарын 17</td><td>Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан.</td></tr>
<tr><td>1 сарын 24</td><td>Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.</td></tr>
<tr><td>1 сарын 27, 28</td><td>Сургууль дээр илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийсэн.</td></tr>
<tr><td>2 сарын 13</td><td>Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.</td></tr>
<tr><td>2 сарын 15</td><td>Шинжээчийн багийн тайланг сургуульд илгээн санал авсан.</td></tr>
<tr><td>2 сарын 23</td><td>Шинжээчийн баг тайланг эцэслэн боловсруулж, ажлын албанд хүлээлгэн өгсөн.</td></tr>
</table>

# II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

**Зорилго:**

Сувилагч мэргэжилтэнг үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд чиглэсэн сувилахуйн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх, бүх шатлалын эмнэлэг, сургууль, цэцэрлэг, урьдчилан сэргийлэх байгууллагуудад ажиллахаар бэлтгэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

**Хөтөлбөрийн хүрэх үр дүн PLOs (Program Learninig Outcomes):**

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сувилахуйн төгсөгчдийн эзэмших цогц чадамжийн томьёолол буюу Канад улсын CanMEDs - ийг ашиглан дараах үр дүнд хүрнэ.

- Мэргэжилтэн байх
- Суралцагч байх
- Манлайлагч байх
- Харилцагч байх
- Багаар ажиллагч ба хамтрагч
- Эрүүл мэндийг дэмжигч

**Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives) :**

- Эрүүл мэндийн сувилахуйн үйлчилгээнд ард иргэдийн сэтгэл ханамжийг байнга нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байх
- Мэргэжилтнүүдэд үндэсний болон олон улсад өрсөлдөх, хөрвөх мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн байх
- Суралцагчид болон багш ажилчиддаа ээлтэй байх

**Сургалтын төлөвлөгөөний бүтэц**

Ерөнхий суурь 14 хичээл, сонгон судлах 4 хичээл, мэргэжлийн суурь 11 хичээл, сонгон судлах 3 хичээл, мэргэшүүлэх 23 хичээл сонгон судлах 3 хичээл, үйлдвэрлэлийн дадлага 4 бүтэцтэй байна.

**Хөтөлбөрийн хичээлийн онол, практикийн харьцуулалт**

2020-2021 онд батлагдсан сургалтын хөтөлбөрт лекц 31%, семинар 37%, дадлага 32% тус тус эзэлж байна.

**Хөтөлбөрийн багш нарын судалгаа**

2021-2022 оны хичээлийн жилд нийт 28 багш бүрэлдэхдүүнтэй байгаагийн сувилахуйн мэргэжлийн үндсэн багш 11, гэрээт багш 6, бусад мэргэжлийн үндсэн багш 8, гэрээт багш 3 ажиллаж байна. Доктор багш 5, магистр багш 22, клиникийн профессор багш 2 байна.

**Хөтөлбөрийн нэг багшид ноогдох оюутны тоо**

2021-2022 оны хичээлийн жилд нийт 28 багш бүрэлдэхдүүнтэй байгаагийн сувилахуйн мэргэжлийн үндсэн багш 11, нийт оюутны тоо 282 байгаа бөгөөд нэг багшид ноогдох оюутны тоо 28 байна.

**Хөтөлбөрийн онцлог:**

Энэхүү хөтөлбөр нь сувилахуйн судлаач Х.Д.Пеплаугийн "хүмүүс хоорондыэ харилцаа нь сувилахуйн чухал үйл явц" онолыг үндэслэн хэрэгжүүлдэг.

Бусад сургуулийн сургалтын хөтөлбөрөөс ялгарах онцлог давуу талаа 5-н сайнаар тодорхойлж гаргасан байна. Сайн тогтолцоо, сайн багш, сайн хөтөлбөр, сайн оюутан, сайн дэмжлэг. Тус хөтөлбөрөөр төгсөгчид нь үйлчлүүлэгч төвтэй тусламж үзүүлэгч, мэргэжилтэн, мэдээлэл зүйч, технологич, нотолгоонд суурилсан тусламж үзүүлэгч,

аюулгүй байдлыг хангагч, харилцагч, багаар ажиллагч ба хамтрагч, чанарыг сайжруулагч байхаар тодорхойлсон байна.

# III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

## Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

*Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.*

**1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

**Илрэл нотолгоо:**

-Сувилагч мэргэжлийн хэрэгцээг олон улсад болон Монголд эрэлт ихтэй байгааг нотолсон судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж хөтөлбөрт тусгасан байна.

-Хөтөлбөрийн шинэчлэл хийхдээ Монгол улсын хууль, дүрэм журам, салбарын сайдын баталсан тушаал, шийдвэрийг үндэслэн, тусгаж хэрэгжүүлсэн байна. \БШУС-ын 2014 оны А/174 тоот, 2014 оны А/78 тоот, 2018 оны А/103 тоот, 2018 оны А/194 тоот, 2020 оны А/270 тоот тушаал\

-Сургалтын хөтөлбөрт 2017-2018, 2019-2020, 2020-2021 онуудад 3 удаагийн шинэчлэл хийсэн байна. Шинэчлэл хийсэн сувилахуйн сургалтын хөтөлбөрийг эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлээгүй байна. Сургалтын хөтөлбөрийг баталсан хурлын тэмдэглэл тушаал байхгүй байна. Сувилахуйн сургуулийн хөтөлбөрийн дэд хороог 2021 оны 1-р сарын 07-ны өдрийн сувилахуйн сургуулийн багш нарын 01 хурлаар байгуулсан байна. Сувилахуйн тэнхимийн хөтөлбөрийн дэд хороо нь хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн талаар удаа дараалан хуралдаж асуудлуудаа хэлэлцэж байсан байна. Харин сургалтын хөтөлбөр шинэчлэх цаг хугацаануудад хөтөлбөрийн ерөнхий хороо болон хөтөлбөрийн дэд хороо байгуулагдаагүй байсан байна.

-Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд сургалтын төлөвлөгөө багц цагийн хувиарлалтын хувьд өөрчлөгдсөн байна. Ерөнхий суурь 35 \29.2%\ багц цаг, мэргэжлийн суурь 30 \25%\ багц цаг, мэргэшүүлэх 55 \45.8%\ багц цаг нийт 120 багц цагийн хичээлүүдийг судлахаар өөрчлөгдөн одоо хэрэгжиж байгаа нь БШУСЯ-ны А/174 тушаал, бакалаврын сургалтын хөтөлбөрийн" нийтлэг шаардлагыг хангаж байна.

| Багц цагийн агуулга | Хөтөлбөрт тавигдах шаардлага | 2017-2018 | | 2019-2020 | | 2020-2021 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | БЦ | Хувь | БЦ | Хувь | БЦ | Хувь |
| Ерөнхий суурь | 30% хүртэл | 39 | 29.5 | 36 | 28.5 | 35 | 29.2 |
| Мэргэжлийн суурь | 25% илүүгүй | 33 | 25 | 31 | 24.6 | 30 | 25 |
| Мэргэшүүлэх | 45% доошгүй | 60 | 45.5 | 59 | 46.9 | 55 | 45.8 |
| Нийт | 100% | 132 | 100 | 126 | 100 | 120 | 100 |

-Сургалтын хөтөлбөрөө дотоод болон гадаадын ижил төстэй сургуулиудын хөтөлбөртэй харьцуулан судалжээ. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн хөтөлбөртэй харьцуулан судалж, агуулга, сургалтын арга зүйг тусгаж хэрэгжүүлж байна.

**Онцлог зүйл:**

- ГУИС-ийн Сувилахуйн сургууль нь сургалтын хөтөлбөрөө эрүүл мэндийн салбарын эрэлт хэрэгцээ, Боловсролын төрийн захиргааны төв байгууллагын бодлогод нийцүүлэн "Монгол улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2015-2024", "Тогтвортой хөгжлийн зорилт 2030", ЭМЯ-ны мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт, хөгжлийн зураглал, сувилагч мэргэжилтэнд тавигдах шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөрийн шинэчлэл хийж ажиллаж байна.

**Анхаарах асуудал:**

- Хийсэн ажлаа баримтжлуулах, баталгаажуулах, нотолгоожуулах ажил учир дутагдалтай байна. Сургалтын хөтөлбөр албан ёсоор баталгаажаагүй нь үүнээс харагдаж байна. Сургалтын хөтөлбөрт 3 удаа шинэчлэл хийгдсэн ч хөтөлбөрийн хороогоор эрдэмтдийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн батлуулсан хурлын тэмдэглэл тушаал байхгүй байна.
- Сургалтын хөтөлбөрийг ижил төстэй гадаад болон дотоодын сургуулийн хөтөлбөртэй харьцуулахдаа нэг биш хэд хэдэн сургуультай харьцуулж дүн шинжилгээ хийх

**Зөвлөмж:**

- Сургалтын хөтөлбөрийг гадаадын болон дотоодын хөтөлбөртэй харьцуулалт хийхдээ агуулга, хичээлийн нэршил, төгсөгчийн эзэмших мэдлэг ур чадвар хандлагыг авч үзэж дүн шинжилгээ хийж өөрийн хөтөлбөрт тусгах.

**Шаардлага:**

- Сургалтын хөтөлбөрт цаашид Эрдмийн зөвлөлийн оролцоог сайжруулж, санал зөвлөмжийг нь тусгах

- Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл хийсэн үйл ажиллагааг хурлын тэмдэглэл, шийдвэр тушаал, санал зөвлөмж, түүний мөрөөр авсан арга хэмжээний тайлан зэрэг баримт бичгийг баталгаажуулах

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл нотолгоо:**

- ГУИС-ийн эрхэм зорилгод нийцүүлэн Сувилахуйн сургууль нь хөтөлбөрийн зорилгоо "Сувилагч мэргэжилтэнг үйлчлүүлэгчийн хэрэгцээнд чиглэсэн сувилахуйн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх, бүх шатлалын эмнэлэг, сургууль цэцэрлэг, урьдчилан сэргийлэх байгууллагуудад ажиллахаар бэлтгэхэд хөтөлбөрийн зорилго оршино" гэж тодорхойлжээ.
- ГУИС-ийн Сувилахуйн сургууль нь сургалтын хөтөлбөрийн төгсгөлд гарах үр дүнгээ "Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн чиглэл \хөтөлбөр\"-д тавигдах нийтлэг шаардлага, мэргэжлийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцүүлэн гарсан байна.
- Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүнгээ тодорхойлохдоо манай оронд ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа бусад сургуулийн сургалтын хөтөлбөрөөс ялгарах онцлог давуу талаа 5-н сайнаар тодорхойлж гаргасан байна. Сайн тогтолцоо, сайн багш, сайн хөтөлбөр, сайн оюутан, сайн дэмжлэг. Тус хөтөлбөрөөр төгсөгчид нь үйлчлүүлэгч төвтэй тусламж үзүүлэгч, мэргэжилтэн, мэдээлэл зүйч, технологич, нотолгоонд суурилсан тусламж үзүүлэгч, аюулгүй байдлыг хангагч, харилцагч, багаар ажиллагч ба хамтрагч, чанарыг сайжруулагч байхаар тодорхойлсон байна. Хөтөлбөрөөр суралцагчид нь 63 төрлийн мэдлэг, АШУҮИС-ийн боловсруулан гаргасан цогц чадамжийг үндэслэн мэдлэг, чадвар хандлагыг эзэмшүүлэх гардан үйлдлийн 174 чадвар, 62 хандлага эзэмшүүлэхээр тусгасан байна.
- ГУИС-ийн Сувилахуйн сургууль хөтөлбөрийн шинэчлэл хийхэд оролцогч талууд болох ажил олгогч, төгсөгчдийн, сувилахуйн чиглэлийн ТББ-ийн төлөөллийг хамруулж 3 удаа уулзалт хийсэн байна.

**Онцлог зүйл:**

Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүнгээ 5-н сайнаар тодорхойлж гаргаж ирсэн байна.

**Анхаарах асуудал:**

- Оролцогч талуудыг оролцуулж 3 удаагийн уулзалтыг хийсэн боловч гарсан санал санаачилга, зөвлөмж байхгүй мөн хөтөлбөрт хэрхэн тусгасан талаар тодорхой биш байна.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрт оролцогч талуудын санал, зөвлөмжийг тусгах ажлыг сайжруулах

**Шаардлага:**

- Төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагад оролцогч, сонирхогч талуудыг оролцуулан үнэлгээ өгөх. Судалгааны үр дүнг сургалтын хөтөлбөрт тусгаж ажиллах

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- 2020-2021 онд шинэчилсэн сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөний дагуу ерөнхий суурь 18 хичээл, мэргэжлийн суурь 12 хичээл, мэргэжүүлэх 27 хичээл суралцах хугацаандаа 4 удаагийн эмнэлгийн дадлага хичээл нийт 57 хичээлийг холбогдох мэргэжлийн тэнхимүүд болон хамтран ажилладаг 17 эмнэлгүүдийг түшиглэн явуулдаг.
- Хичээлийн хөтөлбөрүүд нь сургалтын хөтөлбөрийн үр дүн, агуулгатай мэдлэг, чадвар, хандлагын матриц хийгдэж, хичээл хоорондын залгамж холбоог гаргасан байна.
- Сургалтын арга зүй болон үнэлгээний олон талт аргуудыг ашиглаж оюутан төвтэй, асуудал дэвшүүлсэн, суралцагчид нь бие даан хөгжих, суралцахад чиглэсэн аргуудыг ашигладаг байна.

**Онцлог зүйл:**

- Сувилахуйн судлаачдын онол 2 багц цагаар бие дааж ордог. Бусад сургууль Сувилахуйн үндэс хичээлдээ агуулгыг багтаасан байдаг.
- Жинхэнэ манлайлал хичээл 1 багц цагаар англи хэлээр ордог байна.

**Анхаарах асуудал:**

- Хамтран ажилладаг эмнэлгийн гэрээ дутуу байгааг анхаарч ажиллах

**Зөвлөмж:**

- Хичээлийн хөтөлбөр дутуу байна. Ерөнхий суурь хичээлийн хөтөлбөрүүдийг нөхөн боловсруулах хэрэгтэй
- Сувилахуйн судлаачдын онол хичээлийн нэршил олон улсад Сувилахуйн онол нэршлээр хэрэглэгддэг байгаа тул анхаарах

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан**

## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

*Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.*

**2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Илрэл нотолгоо:**

- БСШУСС-ын 2017 оны А\103тоот, 2020 оны А\262 тоот тушаалуудын дагуу сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал тусгагдах хичээлүүдээс
  - Монгол хэл бичиг найруулга зүй 3 багц цаг
  - Монголын түүх, ёс заншил 3 багц цаг
  - Философи 3 багц цаг
  - Мэргэшүүлэх хичээлд Гамшиг, яаралтай үеийн сувилахуйн тусламж 3 багц цагаар тус тус тусгагдсан байна.
- 2020 онд сургалтын төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлтөөр ерөнхий суурь хичээлээс англи хэлний хичээл  10 багц цагаас 4 багц цаг болж,  хасагдсан, мэдээллийн

технологи 2 багц цаг хичээл нэмэгдсэн, мэргэжлийн суурь хичээлээс сэтгэл заслын үндэс 2 багц цаг, эрүүл мэндийн боловсрол олгох арга зүй 2 багц цаг, молекул биологи 2 багц цаг, эмнэлгийн ажилтны ёс зүй 2 багц цаг, сувилахуйн удирдлага манлайлал 2 багц цаг, тархвар судлал, халдвар хамгаалал 3 багц цаг, сувилахуйн бодлого эрх зүй, судалгааны онол 2 багц цаг тус тус хасагдсан байна. Физиолги 4 багц цагийн хичээл, сувилахуйн судалгаа 3 багц цагаас тус тус 1 багц цагаар хасагдаж өөрчлөгдсөн байна. Эрүүл мэндийн үнэлгээ 3 багц цаг, Сувилахуйн судлаачдын онол 2 багц цаг хичээл шинээр нэмэгдсэн, Сувилахуйн ур чадвар хичээл 2 багц цагаас Сувилахуйн ур чадвар I, II болж 6 багц цаг агууллага нэмэгдсэн, мэргэшүүлэх хичээлд гэмтлийн сувилахуй 2 багц цаг, нөхөн сэргээх сувилахуй 1 багц цаг хасагдаж, сувилахуйн менежмент 2 багц цагийн хичээл нэмэгдэж, хүүхдийн сувилахуй, эх барих эмэгтэйчүүдийн сувилахуй, гэрийн сувилахуй, настны сувилахуй, хавдар хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй хичээлүүдийн багц цаг нэмэгдсэн өөрчлөлт хийгдсэн байна.

- Хөтөлбөрийн багц цагийг агуулгаар авч үзэхэд:

| Багц цагийн агуулга | 2017-2018 | | 2020-2021 | | Хөтөлбөрт тавигдах шаардлага |
|---|---|---|---|---|---|
| | БЦ | Хувь | БЦ | Хувь | |
| Ерөнхий суурь | 39 | 29.5 | 35 | 29.2 | 30% хүртэл |
| Мэргэжлийн суурь | 33 | 25 | 30 | 25 | 25% илүүгүй |
| Мэргэшүүлэх | 60 | 45.5 | 55 | 45.8 | 45% доошгүй |
| Нийт | 132 | 100 | 120 | 100 | Нийт 12 багц цагаар хасагдсан байна |

- 2020-2021 оны хичээлийн жилээс сургуулийн удирдлагын системд Cloud University нэгдсэн системийг нэвтрүүлэн ажиллаж байна.
- Глобал Удирдагч Их Сургуулийн Сувилахуйн сургууль нэртэй веб хуудастай үйл ажиллагаа нь тогтмол үргэлжилдэг, хөтөлбөрөө сурталчилдаг, олон нийтэд болон сувилагч нарт чиглэсэн асаргаа сувилгааны талаарх онлайн сургалт, хамтран ажилладаг гэрээт байгууллагын сувилагч нарын дунд хийсэн уулзалт, сургалт,

оюутнуудын дунд зохион байгуулсан уралдаан тэмцээн гэх мэт үйл ажиллагаагаа таниулдаг сурталчилдаг байна.

- 2020-2021 онд батлагдсан сургалтын хөтөлбөрт лекц 31%, семинар 37%, дадлага 32% тус тус эзэлж байна.
- Дадлагын бааз 17 эмнэлэгтэй хамтран ажиллаж, танхимаар сурсан мэдлэг чадвараа практикаар дадлагажих боломжийг бүрдүүлж, ”Дадлагын нэгдсэн удирдамж” боловсруулсан нь оюутнуудад эмнэлэг дээр дадлага хийхэд юу сурч мэдэх талаар тодорхой болсон байна.
- БНСУ-ын Самюк их сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулж \2018.09.12. №006\ энэ ажлын хүрээнд 2018-2019 хичээлийн жилд богино хугацааны 14 хоногийн сургалт зохион байгуулж 5 багш, 12 суралцагч хамрагдсан байна.
- Суралцагчдын дадлага ур чадварыг сайжруулахын тулд хамтран ажилладаг эмнэлгүүдтэй гэрээ хийж туслах сувилагчаар ажиллуулдаг байна. Энэ ажлынхаа хүрээнд нийт 16 оюутныг туслах сувилагчаар ажиллуулсан байна.
- Хөдөө орон нутгийн засаг захиргаатай хамтран ажилладаг. Дундговь, Өмнөговь, Хэнтий аймгуудын ЗДТГ-тай хамтран ажиллаж гэрээ байгуулсан байна. Энэ ажлын хүрээнд 25 суралцагчийг тухайн орон нутгийн ЗДТГ-ийн тэтгэлгээр сургаж байна.

**Онцлог зүйл:** /Туршлага/

- Сувилахуйн хөтөлбөрөө сурталчлах ажил сайн хийгддэг.

**Анхаарах асуудал:**

- “Дадлагын нэгдсэн удирдамж” - д оюутнуудад эмнэлэг дээр дадлага хийхэд юу сурч мэдэх нь тодорхой байсан харин хэрхэн үнэлгээ авах нь тодорхой бус байна. Хэрхэн үнэлэх үнэлгээг тодорхой болгох

**Зөвлөмж:**

- Сурган заах арга зүй хичээл сонгон судлахаар тавигдсан байна. Хөтөлбөрийн зорилгыг Сувилагч мэргэжилтэнг үйлчлүүлэгчийн хэрэгцээнд чиглэсэн мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх, бүх шатлалын эмнэлэг, сургууль, цэцэрлэг, урьдчилан сэргийлэх байгууллагуудад ажиллахаар бэлтгэхэд оршино гэж тодохойлсон. Энэ зорилгодоо хүрэхийн тулд сувилагч мэргэжилтэн эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх, эрүүл аж төрөх дадалд сургах учраас сурган заах арга зүй хичээлийг мэргэжлийн суурь хичээлд заавал судлуулахаар оруулах хэрэгтэй гэж үзэж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хичээлийн хөтөлбөр нь сургалтын хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн сургалтын болон үнэлгээний олон талт аргыг тусгасан байна. Оюутан төвтэй арга зүйн дагуу явуулж дадлагажих, бие даан суралцах, асуудал шийдвэрлэх, эмнэл зүйн тохиолдол, багаар ажиллах арга зүйг түлхүү хэрэглэж байна.
- Хичээлийн хэлбэр:
  Лекц – үзүүлэн таниулан, өгүүлэн тайларлан заах
  Семинар – мэдлэгийг гүнзгийрүүлэх, бататгах
  Лаборатори – онол арга зүйн мэдлэг, практик чадварыг дууриамал орчинд суралцаж дадлагажих ач холбогдолтой.
- I –IY хичээлийн хөтөлбөрт давхардсан тоогоор 396 арга ашиглагдаж байгаагийн лекцийн сургалт интерактив аргаар 83.2%, PPP – ийн арга 78.9%, цахим сургалтын арга 36.1%, дадлага семинарын хичээлд даалгаварт суурилсан арга 80.7%, баг болон хамтын сургалтын арга 80.7%, асуудалд суурилсан арга 70.1%, тохиолдолд суурилсан арга 43.8%, цахим сургалтын арга 36.1% ашиглагдаж байна.

**Онцлог зүйл:**

- ГУИС-ийн Сургалтын албанаас 7 хоног бүрийн 5 дахь өдөр сургуулийн багш нарт зориулан сурган заах арга зүйн сургалтыг зохион байгуулдаг үүнд сувилахуйн сургуулийн багш нар 100% хамрагддаг байна.

**Анхаарах асуудал:**

- Хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаандаа судалгаа нотолгоотой ажиллах

**Зөвлөмж:**

- Гардан үйлдлийн видео хичээлүүдийг бэлтгэн ашиглах
- Дэвшилтэт технологи ашигласан арга зүйг цаашид сайжруулах

**Шаардлага:**

- Багшлах арга зүй, Сургалтын арга зүйн үр дүнд судалгаа үнэлгээ хийх

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Суралцагчдыг үнэлэхдээ ГУИС-ийн Сувилахуйн сургуулийн “Сургалтын журам”, “Шалгалтын журам” – ыг баримталдаг.
- Сувилахуйн хөтөлбөрт үнэлгээний мэдлэг үнэлэх, ур чадвар үнэлэх, цогц чадамж үнэлэх аргуудыг багтаасан ба суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагын түвшинг харгалзан шалгалтын арга хэлбэрүүдээс тохиромжтойг сонгон хэрэглэдэг байна.

**Онцлог зүйл:**

- Оюутны сургалтын хөтөч боловсруулан ашигладаг. Оюутны хөтөч-д сургалтын үйл ажиллагааг ямар хэлбэрээр зохион байгуулах, сэдвийн агуулга, эзэмших мэдлэг, чадвар, хандлага, үнэлгээ, сургалтад тавигдах шаардлага зэрэг багтсан байгаа нь оюутны сурах үйлийг чиглүүлэхэд ач холбогдолтой.

**Анхаарах асуудал:**

- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлдэг арга зүйдээ судалгаа хийж үр дүнгээр хөтөлбөрийг тасралтгүй сайжруулж ажиллах

**Зөвлөмж:**

- Явцын шалгалт болон шалгалтын үнэлгээний арга хэлбэрт судалгаа хийж, шалгалтанд хэрэглэдэг сорил, тохиолдлын тоо, асуулт даалгавар гэх мэтэд үнэлгээ өгч, үр дүнд тулгуурлан сайжруулалт хийх
- Суралцагчдын сурлагын амжилт, чанарт судалгаа хийж үр дүнд уялдуулан хөтөлбөрийг сайжруулах

**Шаардлага:**

- Судалгаа анализ хийж ажиллах

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан**

## Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

*Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.*

**3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- ГУИС нь 1,9 га газар 3904 мкв ашигтай талбайтай 2 хичээлийн байранд үйл ажиллагаа явуулж байна. 2 дахь хичээлийн байр нь 2019-2020 оны хичээлийн жилд ашиглалтад орж, хичээлийн байрны 3,4-р давхарт Сувилахуйн сургууль нь сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Лекцийн 2 өрөө, семинарын хичээл явагдах 2 өрөө, сувилахуйн ур чадварын сургалт явагдах 5 өрөөтэй, багш нарын 2 өрөө, оюутны бие даан суралцах, судалгааны 1 өрөө, архивын агуулах 1 өрөө, эрэгтэй эмэгтэй ОО –ийн өрөөтэй байна.
- Хичээл сургалт явагдах өрөөнүүд гэрэлтүүлэг сайтай, саруулхан, гадна орчны гудамжны дуу чимээ сонсогдохгүй, агааржилт сайтай байна.
- Багш нар өрөө тохижилт сайтай, тус тусдаа ширээ суурин компьютертэй, гал тогооны хэсэгтэй хамтран тойргоор сууж цайлах болон санал бодлоо хуваалцах өрөөтэй.
-Сувилахуйн ур чадварын сургалт явагдах 5 өрөө тус тусдаа сувилахуйн гардан ажилбар хийх хэрэглэгдэхүүн, муляж бусад хэрэгслэлээр тоноглож тохижуулан сувилахуйн гардан ур чадварын дууриамал орчинг бүрдүүлэн ажиллаж байна. Лекц болон семинарын хичээл явагдах өрөөнүүд нь бүрэн тоноглогдсон байна.

**Онцлог зүйл:** /Туршлага/

- Сувилахуйн гардан үйлдлийн ур чадварын 5 өрөөг тус тусад нь төрөлжүүлэн \хэвтрийн өвчтөнд үзүүлэх тусламжийн, тарилга хийх, эх, хүүхдийн сувилахуйн, мэс засал яаралтай тусламжийн\ гардан үйлдлийн сургалтын хэрэглэгдэхүүнээр тохижуулан сургалт зохион байгуулдаг.

**Анхаарах асуудал:**

- Лекцийн 2 өрөөний нэг талын хана нэлэнхүйдээ шилэн \цонх\ байгаа нь самбарт тусах тусгалыг бууруулах талтай тул анхаарах
- Оюутны бие даан суралцах судалгааны өрөөг компьютертэй болгож, интернетээр бүрэн хангаж өгөх

**Зөвлөмж:**

- Тарилгын өрөөнд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллахад анхаарах

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Багшийн сургалтын хэрэглэгдэхүүнд зориулагдсан суурин компьютер, принтер, бичгийн цаас, самбарын үзэг зэргээр сургуулиас хангадаг. 2021-2022 оны Сувилахуйн сургуулийн санхүүгийн төсөвт бичиг хэрэг – 500.000, эд хогшил худалдан авах зардалд 25.000.000, компьютер тоног төхөөрөмж худалдан авахад 3.000.000 төгрөг тус тус зарцуулахаар төсөвлөгдсөн байна.
- Оюутанд сувилахуйн ур чадвар хичээлд хэрэглэгддэг материалыг хангаж өгдөг нь оюутантай хийсэн ярилцлагаар нотлогдсон. Үүнд тариур, нэг удаагийн болон ариун бээлий, хөвөн марль, ариутгалын бодис, туншил флаконтой эмийн бодис зэргийг хангалттай олгодог байна. Сувилахуйн ур чадварын хичээлийн хэрэглэгдэхүүнд тарилга хийдэг судас тарилганы гар, сарвууны муляж, өгзөг муляж, арьс доторх тарилга хийх гарын шуу муляжтай байна. Оюутнууд нь бүх төрлийн тарилгаа муляж дээр хатгалт хийж дадлагажиж суралцдаг. Дадлагажсаны дараа багшийн удирдлаган дор оюутнууд бие биедээ өөрсдөдөө хатгалт хийж суралцдаг. 2021-2022 оны Сувилахуйн сургуулийн санхүүгийн төсөвт сургалтын үйл ажиллагааны зардалд 6.000.000 төгрөг зарцуулахаар төсөвлөгдсөн байна.

**Онцлог зүйл:**

- Тэнхимийн багш нар гардан ажилбарын өрөөнд ажиллах журамтай түүнийг мөрдөн ажилладаг байна.
- Оюутнууд тарилгыг муляж дээр хийж дадлагажсаны дараа өөрсдөдөө хийж суралцдаг. Тарилгын хатгалт хийхдээ бие биеэсээ зөвшөөрөл авч багш нар нь тариулах зөвшөөрлийн хуудас бөглүүлж зөвшөөрөл авсны үндсэн дээр хатгалт хийдэг байна.

**Анхаарах асуудал:**

- Сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж, ашиглалтын талаар судалгаа хийж, гарсан үр дүнд тулгуурлан хэрэгжилтэд тусгаж ажиллах

**Зөвлөмж:**

- Тарилгын хуучирсан муляжийг шинэчилж, тоог нэмэгдүүлж, суралцах давтамжийн тоо болон хүрэлцээг сайжруулах

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**3.3. Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай

хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Номын сан нь 32 суудалтай уншлагын танхим, 32 компьютер бүхий цахим уншлагын танхим, нээлттэй чөлөөт уншлагын танхимтай, номын сангийн LIB4U программ ашигладаг 3 номын санчтай үйлчилгээ үзүүлэн ажилладаг байна.
- Сувилахуйн ерөнхий суурь хичээл, мэргэжлийн суурь хичээл, мэргэшүүлэх хичээлийн номын фонд 461 ш номтой байна. 2017-2018 оны хичээлийн жилд нийт 132 багц цагийн 60 хичээлийн 15 хичээл нь буюу 33.3% ном сурах бичгийн хангалттай байсан бол 2021-2022 оны хичээлийн жилд 120 багц цагийн 57 хичээлийн 45 хичээл нь буюу 80.3% ном сурах бичигтэй болсон байна. Энэ нь сурах бичгийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгааг харуулж байна.
- Цахим номын санд 150 сурах бичиг ном байршуулсанаас сувилахуйн сурах бичиг 12ш байна.

**Онцлог зүйл:**

- Номын сангийн орчин нөхцөл сайн, дуу тусгаарлагчтай орчин бүрдүүлж чадсан байна.
- Номын сан зай талбай ихтэй оюутан баг бүлгээр сууж ажиллах чөлөөт уншлагын танхимтай байна

**Анхаарах асуудал:**

- Цахим номын сангийн хандалтын тоо байхгүй
- Номын сангаар үйлчлүүлэгчдийн тоо, голчлон ашигладаг сурах бичгийн тоо, сэтгэл ханамжийн талаар судалгаа хийж гарсан үр дүнг тусгаж ажиллах

**Зөвлөмж:**

- Электрон номын сангийн хандалтын тоог нэмэгдүүлэх, оюутнуудад сурталчлан таниулах ажил хийх

**Шаардлага:**

- Сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд ном сурах бичгийн ашиглалт, хүртээмжийн талаар оролцогч талуудын сэтгэл ханамжийг судалж судлагааны мөрөөр, үр дүнг тусгаж ажиллах

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

*Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.*

### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

-Хөтөлбөрийн хороог ГУИС-ийн захирлын 2021 оны 02 тоот тушаалаар 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. 5 удаа хуралдаж 18 төрлийн асуудал шийдвэрлэсэн хурлын тэмдэглэл бүрэн, түүний дагуу авсан арга хэмжээ авсан баримттай.

-Сувилахуйн сургуулийн хөтөлбөрийн хороо (хөтөлбөрийн дэд хороо)-г 2021 оны 1-р сарын 07-ны өдрийн сувилахуйн сургуулийн багш нарын 01 хурлаар байгуулсан байна.

-Хөтөлбөрийн дэд хороо нь 2020.10.20, 2020.12.18, 2021.06.11, 21.08.06-ны өдрүүдэд хуралдаж, сувилахуйн сургуулийн мэргэжлийн хөтөлбөр, цахим сургалт, бакалаврын хөтөлбөрийн агуулласгын хуваарилалт зэрэг 15 асуудлыг хэлэлцэж тухай бүрд нь өөрсдөө болон их сургуулийн удирдлагад уламжлан шийдвэрлэж ажиллажээ.

-Захирлын 2021 оны 9-р сарын 25-ны өдрийн А/67 тоот тушаалаар Эрдмийн зөвлөлийг байгуулсан боловч одоогийн байдлаар уг эрдмийн зөвлөл “Сувилахуйн сургалтын хөтөлбөр”-ийн асуудлыг авч хэлэлцээгүй байна.

-2020-2021 онд Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалтад анхаарч хөтөлбөрийн хороо, профессорын баг ажиллуулж 7 хоног бүрийн баасан гаригт хөтөлбөрийн асуудлыг хэлэлцэж ажилласан нь сайн байна.

-2020-2021 онд сувилахуйн 57 хичээлийн хөтөлбөрт үнэлгээ хийж 3 үе шаттайгаар сайжруулалт хийсэн талаар өөрийн үнэлгээний тайланд дурдсан боловч тухайн хөтөлбөрүүдийг шинэчлэхийн тулд ямар асуудлуудыг хэрхэн авч хэрэгжүүлсэн, юуг нь яаж сайжруулсан талаар хурлын тэмдэглэлд тодорхой байхгүй байна.

-Сургуулийн удирдлага мэдээллийн системд Cloud University программыг хэрэглэж эхэлсэн байна. Уг систем нь багшийн, оюутны, удирдлагын веб систем гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс тогтсон. Тогтмол ажиллагаатай болсон нь багш ажилтан оюутнууд цахим орчинд тогтмол харьцаатай байж, оюутны тасралтгүй сурах үйл ажиллагааг дэмжсэн

чухал алхам болжээ. Энэхүү програмд сургалтын алба багш оюутны бүртгэл, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хуваарь, дүнгийн архив, тайлан мэдээ, мэдээлэл харилцаа, төлбөрийн бүртгэлийг оруулан хянах боломжтойгоор хийгджээ. Энэ программын зэрэгцээ 2022 оноос google meeting, google classroom зэрэг сошиал орчны программыг ашиглаж эхэлсэн нь ашиглахад тохиромжтой, хялбар, хүртээмж сайтай байгааг багш нарын эрхээр орж танилцлаа.

- 2021 оноос сургалтын үйл ажиллагаанд "MainxCloud" программыг хэрэглэх тухай ГУИС-ийн захирлын 2021 оны 1-р сарын 7-ны өдрийн 21/01 тоот тушаалаар батлан хэрэгжүүлсэн байна. Энэ ажлын хүрээнд бүх оюутнууд хувийн кодтой, багш нар уг хичээлд хэн оролцсоныг хянах боломжтойгоос гадна, оюутнууд сургалтын талаар санал хүсэлтээ илгээж, уг санал хүсэлтийг хөтөлбөрийн агуулгад тусгах арга хэмжээ авч ажиллуулж байна.

**Онцлог зүйл:**

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг 7 хоног бүрийн баасан гаригт хөтөлбөрийн асуудлыг авч хэлэлцдэг.

**Анхаарах асуудал:**

- Хурлын тэмдэглэл, тушаал шийдвэрийн бичвэр ойлгомжгүй, он сар зөрүүтэй, хийгдсэн ажлуудын уялдаа холбоог сайжруулах
- Хөтөлбөрийн талаар хэрэгжүүлсэн бүх үйл ажиллагааг /хурлын тэмдэглэл, шийдвэрэлэсэн тушаал тогтоол, арга хэмжээний тайлан зэрэг/ баримтжуулан хөтлөх хэргийн жагсаалт гарган архивжуулах

**Зөвлөмж:**

- Сургалтын хөтөлбөрт Эрдмийн зөвлөлийн оролцоог сайжруулах
- Захирлын тушаал шийдвэр, хурлын тэмдэглэл, зэрэг баримт бичгийн боловсруулалтад МУ-ын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" болон MNS 5140-1,2,3-2021 стандартуудыг баримтлан ажиллах, энэ талаар багш холбогдох ажилтнуудад сургалт явуулах.

**Шаардлага:**

- Эрдмийн зөвлөл, хөтөлбөрийн хороо, профессорын багийн үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан хөтөлбөрийн талаар хэрэгжүүлж буй арга хэмжээг баримтжуулах

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Монгол улсад сувилахуйн мэргэжилтэн бэлтгэдэг АШУҮИС-ийн сувилахуйн сургууль, Энэрэл дээд сургууль, МҮИС-ийн сувилахуйн сургуультай хамтын үйл ажиллагаа явуулж, багш нарын туршлагаас суралцах, цахим сургалт хийх зэрэг олон талт үйл ажиллагааг явуулсан талаар тайланд дурдсан бөгөөд газар дээр нь үзэж танилцахад хамтран хэрэгжүүлсэн олон үйл ажиллагааг зураг, видео бичлэгээр баримтжуулсан байна. Гэсэн хэдий ч дээрх байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, хамтран зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөгүй, тайлангаар баталгаажаагүй байна.
- Өөрийн үнэлгээний тайланд БШУЯ, ЭМЯ, ЭМХТ, Нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд, ЭМЯ-ны Сувилахуйн Мэргэжлийн Салбар Зөвлөл зэрэг төрийн байгууллагууд, “Сувилахуйн амьдрал төв”, “Өрхийн мэргэшсэн сувилахуйн төв”, “Халдвартын сувилагчдын нийгэмлэг” зэрэг ТББ-дтай хамтран ажилласан талаар бичсэн боловч газар дээр нь үзэхэд хамтын ажиллагааны гэрээ, төлөвлөгөө, тайлан байхгүй харин хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны зураг, бичлэг CD дээр болон байгууллагын цахим хуудсанд байна.
- ОХУ, Тайван, Япон, Солонгос, БНХАУ зэрэг гадны улсуудтай мэргэжлийн чиглэлээр харилцаа тогтоон хамтран ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

**Онцлог зүйл:**

- Мэргэжлийн нийгэмлэг, төрийн бус байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран ажиллаж байна.

**Анхаарах асуудал:**

- Хамтын ажиллагааны гэрээ, төлөвлөгөөг тодорхой хийж байх.

**Зөвлөмж:**

- Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай хамтран ажиллахдаа гэрээ байгуулж, хөдөлбөрийг сайжруулах хөгжүүлэх тал дээр тухайн байгууллагаас ямар дэмжлэг туслалцаа авах хамтран ажиллах тодорхой төлөвлөгөөтэй, үр дүнг тооцож хэвших.

**Шаардлага:**

- Төрийн болон ТББ, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах үйл ажиллагааг баримт нотолгоог сайжруулах

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Санхүүжилтийн дийлэнх хэсэг нь сургалтын төлбөрийн орлого бүрдүүлдэг байна.
- Санхүүжилтийн тодорхой хувийг хөтөлбөрийн шинэчлэл хийх болон багшийн мэргэжил дээшлүүлэхэд зарцуулжээ.
- Нэг оюутанд ноогдох дундаж орлого, зардлыг 2021-2022 оны хичээлийн жилд тооцсон байна. Үүнд: 1 оюутанд сардаа 41.615, жилдээ 487,949 төгрөгийн зардал гарахаар, 1 оюутнаас жилдээ 2.393,961 төгргийн орлого орохоор тооцоолсон байна. Сургуулийн санхүүгийн үндсэн эх үүсвэр нь суралцагсдын төлбөр байдаг байна.

**Анхаарах асуудал:**

- Санхүүжилтийн хувьд үндсэндээ сургалтын төлбөрөөс бүрдэж байгаа нь хангалтгүй байна.
- Багш нарын хөгжилд зарцуулж буй санхүүжилт бага.

**Зөвлөмж:**

- Санхүүжилтийг олон эх үүсвэртэй болгох.
- Багш нарын хөгжилд зориулах санхүүжилтийг судалгаанд үндэслэн урт богино хугацаагаар төлөвлөх
- Гардан сургалтын материалд зарцуулах эм, эмнэлгийн хэрэгсэл, сургалтын муляж зэрэг хэрэглэгдэхүүнийг худалдан авах өртөг зардлын судалгаанд суурилан оновчтой хийх.

**Шаардлага:**

Санхүүжилтийг боловсронгуй болгох төлөвлөгөө гарган багшийн хөгжил, эмнэл зүйн сургалтын хангамжид зарцуулах хувийг тогтоон, дотоод дүрэм журмаар баталгаажуулан санхүүжилтийн нөхцөлийг тодорхой тогтвортой байдлыг хангах ажиллах.

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Илрэл нотолгоо: Үүний эхний параграфийг 4.5 руу оруулсныг анхаарна уу.**

- 2019-2021 онуудад Өмнөговь, Дундговь, Архангай, Баян-Өлгий, Дархан-Уул, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Ховд аймгуудад танилцуулга сурталчилгааг багаараа явж хийж 500 хүнд мэдээлэл түгээсэн байна.
- 2020-2021 онуудад УБ хотын дүүргүүдийн ЕБС-иудаар бие төлөөлөгчөө явуулан суригуулийн үйл ажиллагааг сурталчилсан байна.
- Танилцуулга сурталчилгааг багаараа зохион байгуулж, 600 хүнд мэдээлэл түгээсэн байна.
- 2019-2021 онуудад ГУИС-ийн https://www.facebook.com/GlobalLeadershipUniversity ФБ пэйж хуудсаар сувилахуйн сургалтын талаар 36 удаа шууд ярилцлаыг сард 1 удаа хийж, 55000 хүн үзэж 15000 хүн хуваалцсан байна.
- 2020-2021 онуудад ГУИС-ийн Сувилахуйн сургуулийн https://www.facebook.com/glunursing пэйж хуудсаар сувилахуйн сургалтын талаар сард 2 удаа шууд ярилцлага хийж, 70000 хүн үзэж 48000 хүн хуваалцсан байна.

**Онцлог зүйл:**

- Дараах пэйж хуудсуудаар сургалтын талаарх сурталчилгаа, шууд ярилцлага, контентуудыг боловсруулан тогтмол явуулж, дагагчдын тоо жилээс жилд нэмэгдсэн байна.

https://www.facebook.com/GlobalLeadershipUniversity

https://www.facebook.com/glunursing

**Анхаарах асуудал:**

- Хэдийгээр маркетингийг олон сувгаар явуулж байгаа ч хөтөлбөрийн агуулгыг олон нийтэд хүргэх, хүртээмжийг сайжруулахын тулд хөтөлбөрийн маркетингийг хариуцан тогтвортой ажиллах орон тооны мэргэшсэн ажилтан одоогоор байхгүй байна**.**

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахуйц идэвхжүүлэлтийн төлөвлөгөөг батлан улирал жилээр үр дүнг тооцон ажиллаж хэвших.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

**Илрэл нотолгоо:** /Шаардлагатай холбоотой баримт бичиг, тоо баримт, судалгааны дүн гэх мэт судалсан бодит илрэл баримтуудыг бичнэ/

- Сургуулийн ФБ хуудсаар дамжуулан сургуулийн танилцуулга, сувилахуйн сургалтын талаарх видео контентуудыг боловсруулан тогтмол цацдаг бөгөөд энэ хуудас нь анх 1000 гаруй дагагчтай байсан бол одоо 50000 гаруй тогтмол дагагчтай, тогтмол цааш хуваалцах байдлаар мэдээлэл нь өдөр тутам тогтвортой сурталчлагддаг байгаа нь сошиал цахим орчинд идэвхижүүлэлт сайн байгааг харуулж байна. Үүнд: Сувилахуйн хөтөлбөрийг UBS телевизийн Кофе юу? Цай юу? нэвтрүүлгээр албан ёсоор сурталчилдаг бөгөөд мөн Сувилахуйн сургуулийн 2 фэйсбүүк хуудсаар дамжуулан сар бүр Сувилагч мэргэжлийн үнэ цэнэ, төрөлжсөн сувилахуйн мэргэжлийн багш нарын сургалтууд, гардан үйлдлийн сургалтууд зэрэг сэдвүүдээр тогтмол контент оруулсан байна. Фэйсбүүкээр нийтдээ 60 гаран цагийн шууд ярилцлага болон бичлэг хийсэн байна. Үүнд: 2018-2022 онуудад UBS TV "Кофе юу цай юу" нэвтрүүлгээр 36 удаа сурталчилсан байна.

Сувилахуйн сургалтын үйл ажиллагааг харуулсан 12 видео бичлэг сургуулийн Глобал Удирдагч Их Сургууль (glu.edu.mn) цахим хуудас болон https://www.facebook.com/glunursing https://www.facebook.com/GlobalLeadershipUniversity. Цахим хуудсуудад тавигдсан байна.

**Онцлог зүйл:** /Туршлага/

- Сувилахуйн сургалтын тодорхой сэдвүүдээр хариуцсан багш нар нь ярилцлага болон гардан хичээлүүдийг цахим хуудсанд болон сургалтын цахим програмд байршуулсан нь зөвхөн Глобал удихдагч их сургуулийн Сувилахуйн оюутнуудад хэрэгтэй төдийгүй, сувилахуйн чиглэлээр суралцаж буй оюутан мэргэжилтнүүдийн чухал гарын авлага болсон байна.
- Сувилахуйн хөтөлбөрийн талаар олон нийтэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар , сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг нь сайн үйлчилгээ болсон байна

**Анхаарах асуудал:**

- Олон нийтийн сүлжээнд тавьж буй мэдээллийн үг хэллэгийн сонголтонд анхаарч, хяналт тавьж ажиллах

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан**

## Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

*Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.*

**5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

